

## **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО, АГУУЛГА**

### **I. Үзэл санаа, зорилго**

Япон, Хятад, Солонгос, Монгол, Бирм улсуудын янз бүрийн байгалийн баялгийг үр ашигтай, зөв зохистой ашиглах, байгаль орчноо хамгаалах талаар бодит үйл ажиллагаан дээр тулгуурласан боловсролыг түгээх, олон нийтэд энэ талын боловсролыг түгээн сурталчилах нь бидний гол зорилго билээ.

Гадаад хүмүүстэй хамтран ажилласнаар бусаддаа үлгэр жишээ болсон манлайлагчийг бэлдэхийн зэрэгцээ байгалийн эко-систем, байгаль эхтэйгээ зэрэгцэн амьдрах тухай олон нийтэд таниулан сурталчилах зэрэг олон талт үйл ажиллагаанд тулгуурласан байгаль орчноо хамгаалах боловсролын сүлжээг бий болгохын төлөө зорин ажиллаж байна.

### **II. Үйл ажиллагааны цар хүрээ**

- Хөдөө орон нутаг болон Азийн орнуудын хүрээнд байгаль орчноо хамгаалах тухай олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх сургалт семинарыг Япон улсад зохион байгуулж, түүн дээр тулгуурлан Хятад, Солонгос, Монгол, Бирм улсууд дахь харилцагч байгууллагуудтай хамтран сургалт семинар зохион байгуулж, энэ чиглэлийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэн гаргах.

- Орон орны үйл ажиллагааны байдал, үр дүнг цахим ертөнцөөр дамжуулан мэдээлэх зэрэг ажлыг тасралтгүй хийхийн зэрэгцээ дээрх Азийн таван орны гол мөрний сав бүс нутаг дахь олон хэлбэрт соёл, нутгийн уугуул хүмүүсийг хооронд нь холбох байгаль орчноо хамгаалах сүлжээг үүсгэх.

### **III. Бидний зорилт**

Үйл ажиллагааны гарааны жил буюу 2009 оны зорилго:

1. Орон нутаг болон Азийн орнуудын хүрээнд байгаль орчноо хамгаалах тухай олон нийтийн ухамсар ойлголтыг дээшлүүлэхын төлөө “Чикюү Коллеж” (чикюү: дэлхий, ертөнц гэсэн утгатай япон үг) сургалт семинарыг Япон улсад зохион байгуулав. /Япон улсаас 30 хүн оролцов./
2. “Чикюү Коллеж” семинарт усны эко системийн талаар танин мэдэхүйн зорилгоор “Гол” гэсэн сэдвээр семинарын төлөвлөгөөг боловсруулж, түүн дээр тулгуурлан зохион байгуулах, заан сургах үйл ажиллагааг явуулах. Энэхүү семинарын төлөвлөгөөг Япон улсад хэрэгжүүлэн “Чикюү Коллеж” семинарыг төлөвлөгөөг шалгаж, сайжруулах, засан боловсруулж эцсийн сайжруулсан төлөвлөгөөг бэлтгэх.

3. Орон нутаг болон Азийн орнуудын хүрээнд байгаль орчноо хамгаалах тухай олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх үйл ажиллагааг сонирхогч Япон болон Азийн бусад орны хамтран ажиллагч хүмүүст үйл ажиллагааны явц, үр дүнг интернэтээр мэдээлэх /Япон, Англи хэл дээр/.
4. Японд зохион байгуулсан семинарын үйл явц, аргачлал, семинарын агууллага төлөвлөгөө, мэдээлэл түгээх арга зэргийг загвар болгон хоёр дахь жилээс эхлэн Азийн бусад оронд түгээн дэлгэрүүлэхийн тулд, Хятад, Солонгос, Монгол, Бирм гэсэн дөрвөн улсад “Чикюү Коллеж” семинарыг зохион байгуулахтай холбогдуулан бэлтгэл уулзалтыг зохион байгуулна. Энэ мэтчилэн эхний жилдээ зорилго, зорилтоо төлөвлөж 2010, 2011 онуудад доор дурдсан үйл ажиллагаатай уялдуулан үргэлжлүүлэх болно.
5. “Чикюү Коллеж” семинарыг Япон улсад жил бүр зохион байгуулж, сургалтын чанарыг сайжруулна. Түүнчлэн, олон нийтэд манлайлан таниулах чавдарлаг хүмүүсийг сурган бэлтгэх /Жил бүр 30 хүн/. Хоёр дахь жилээс зохион явуулах “Чикюү Коллеж” семинарт оролцогч орон орны оролцогчидод гуравдахь жилд Японд зохион байгуулагдах “Чикюү Коллеж” семинарыг зохион байгуулахад оролцуулах зэргээр сурч мэдэх дадлагажих боломж олгох.
6. Дэлхийн 4 улсад “Чикюү Коллеж” семинарыг зохион явуулж, байгаль орчны талаархи боловсролыг түгээн таниулах сургагч манлайлагчийг бэлтгэх /Нэг жилд дөрвөн орны нийт 80 хүн/. Мөн, Японы сургагч манлайлагчийг орон орны “Чикюү Коллеж” семинарыг зохион байгуулахад зөвлөгч туслагчаар илгээж хамтран ажиллах.
7. Орон орны үйл ажиллагааны явц, үр дүнг интернэтээр мэдээлэх. /Япон, Англи хэлээр /
8. “Чикюү Коллеж” семинараас олж авсан үр дүн, тулгамдсан асуудал, байгаль орчноо хамгаалах тухай боловсролыг түгээн дэлгэрүүлэхтэй холбогдуулан энэ талаар ярилцаж санал солилцох орчин нөхцөлийг бүрдүүлэх.
9. Гурав дахь жил болох 2011 онд орон орны бага, дунд сугуулийн сурагчидад усны эргэлт ба байгаль дэлхийтэйгээ зэрэгцэн амьдрах, үүний тулд хэрхэн зөв харицах тухай таниулан сурталчилах боловсролын үйл ажиллагааг явуулахын төлөө хэтийн төлөв, бодлого боловсруулан хэрэгжүүлэн ажиллах. /цуврал кино бүтээх, тараах/
10. Гурван жилийн үйл ажиллагаа, сүлжээг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх талаар гүнзгийрүүлэн ажиллах. / интернэт, цахим хуудас ашиглан Ази тивийн гол мөрны сүлжээг бий болгох/